



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№46 /490/

2023.03.20

Цаг үе, үйл явдал

ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ БХЯ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНД ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЛЭЭ



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ өнөөдөр Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнтэй уулзлаа.

Ерөнхий сайд Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 102 жилийн ойн баярын мэндийг нийт генерал, офицер, ахлагчид, хугацаат цэргийн алба хаагчдад дэвшүүлээд, дэлхий дахиныг хамарсан цар тахлын хүнд үед өргөсөн тангарагтаа үнэнч байж, ард түмэн, эх орноо батлан хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлсэнд талархал илэрхийллээ.

Мөн тэрбээр дэлхий дахин, улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, Засгийн газрын үйл ажиллагаа, Шинэ сэргэлтийн бодлогын

талаар бие бүрэлдэхүүнд танилцуулаад Монгол Улсын эдийн засаг цар тахлын дараа сэргэж буй ч тогтворгүй, авлигажсан систем улс орны дотоод аюулгүй байдалд заналхийлж, гадна талаас геополитикийн нөхцөл байдал хүндрэл учруулж буйг дурдаад энэ бүхэн шинэ стандартаар цааш явах хэрэгтэйг сануулж байна гэв.

Монгол Улсын Засгийн газраас Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж эхлээд жил гаруйн хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд боомт, аж үйлдвэрийн сэргэлт, төвлөрлийг сааруулах, төрийн бүтээмжийг дээшлүүлэх томоохон төслүүд эхлээд байна. БХЯ, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн боомтын сэргэлт болон төвлөрлийг сааруулах, хот хөдөөгийн

сэргэлтийн ажилд манлайлан оролцож байгааг Ерөнхий сайд онцолсон ба “Шинэ сэргэлтийн бодлого”, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого нь Монгол Улсын ойрын 30 жилийн хөгжлийн бодлого бөгөөд эдгээрийн хэрэгжилтээс улс орны хөгжил хамаарна.

Иймд БХЯ, Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн идэвхтэй оролцож, хамтран ажиллахыг уриаллаа.

Засгийн газраас зэвсэглэл техникийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, 2024 оноос хугацаат цэргийн албан хаагчдын тоог нэмэх, “Оюутан цэрэг” хөтөлбөрийг өргөжүүлэх зэрэг зорилт тавин ажиллаж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХОЁР ДАХЬ ЗУУНЫХАА ТҮҮХИЙГ БИЧИЖ БАЙНА



“Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж, хөгжсөний 102 жилийн ойн баярын хурал, хүндэтгэлийн арга хэмжээ боллоо.

Баярын хуралд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд дэслэгч генерал Г.Сайханбаяр, Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын нэгэн чухал түшиг тулгуур, нийгмийн шинэчлэгч, манлайлагч, бүтээн байгуулагч гол хүчин байсаар ирсэн бахархам түүхтэй. Өнгөрсөн зууны түүхэнд Монгол Улсын Зэвсэгт хүчин улс орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа төдийгүй төрийн бодлогын нэгэн чухал түшиг тулгуур, нийгмийн шинэчлэгч, манлайлагч, бүтээн байгуулагч гол хүчин байсаар ирсэн бахархам түүхтэй. Өнгөрсөн зууны түүхэнд Монгол Улсын Зэвсэгт хүчин Монгол цэрэг-дэлхийн цэрэг хэмээх хүндлэлийг хүртэж, НҮБ-д цэрэг хандивлагч орнуудаас 24 дүгээрт эрэмбэлэгдсэн нь чамлахааргүй амжилт юм” гээд баярын мэндийг дэвшүүлж, амжилт бүтээлийн дээдийн хүсэн ерөөв.

Мөн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр “Өнөөдөр бол өргөн утгаараа иргэн бүрийн эх орныхоо өмнө өөрийн хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлах, эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо үнэ цэн, утга учрыг ойлгох, түүний мөн чанарыг нандигнан эрхэмлэх, өнөөдрийн бидний энх тунх, аз жаргалтай амьдралын төлөө хайртай бүхнээ золиослон тэмцсэн баатарлаг

байтарлаг, дайчин уламжлал нь монголчууд бидний уруудан доройтож, сэргэн мандсан буурал түүхийн хуудаснаа хадгалагдаж, зуун зуунаар өртөөлсөн хөгжил дэвшил, амжилт ололтоор баяжигдан эдүгээ бидэнд ирсэн. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалаас хойш түүхэн цаг хугацаанд Монгол Улсын Зэвсэгт хүчин улс орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа төдийгүй төрийн бодлогын нэгэн чухал түшиг тулгуур, нийгмийн шинэчлэгч, манлайлагч, бүтээн байгуулагч гол хүчин байсаар ирсэн бахархам түүхтэй. Өнгөрсөн зууны түүхэнд Монгол Улсын Зэвсэгт хүчин Монгол цэрэг-дэлхийн цэрэг хэмээх хүндлэлийг хүртэж, НҮБ-д цэрэг хандивлагч орнуудаас 24 дүгээрт эрэмбэлэгдсэн нь чамлахааргүй амжилт юм” гээд баярын мэндийг дэвшүүлж, амжилт бүтээлийн дээдийн хүсэн ерөөв.

Мөн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр “Өнөөдөр бол өргөн утгаараа иргэн бүрийн эх орныхоо өмнө өөрийн хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлах, эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо үнэ цэн, утга учрыг ойлгох, түүний мөн чанарыг нандигнан эрхэмлэх, өнөөдрийн бидний энх тунх, аз жаргалтай амьдралын төлөө хайртай бүхнээ золиослон тэмцсэн баатарлаг

үйлстнүүдийн дурсгалыг хүндэтгэх, үйл хэргийг нь мөнхжүүлэх, залуу үеийнхэнд үлгэр дуурайлал болгон сурталчлах, энэ л үйлсийн төлөө хөлсөө дуслуулан хөдөлмөрлөж, өргөсөн тангарагтаа эзний ёсоор хандаж буй мянга, мянган алба хаагчдадаа талархах, хүндэтгэл илэрхийлэх учиртай түүхт өдөр юм” гэлээ.

Түүнчлэн Монгол Улсын Зэвсэгт хүчин хоёр дахь зууныхаа түүхийг хэдийнээ эхлүүлж, бүтцэдээ тусгай хүчний, кибер аюулгүй байдал, барилга-инженерийн шинэ төрлийн цэргийг бий болгон хөгжүүлж, түүхт 102 жилийн ойгоо өмнөө дэвшүүлсэн зорилго зорилтоо биелүүлэхийн зэрэгцээ улс орныхоо хөгжлийг урагшлуулсан ололт, амжилт дүүрэн угтаж байгааг онцолсон юм.

Үүний дараа Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн “Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 102 жилийн ойд зориулсан баярын мэндчилгээг Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх дэслэгч генерал Ц.Тогоо уншиж танилцуулав. Мөн энэ үеэр эрхэлсэн албандаа үр бүтээлтэй ажилласан алба хаагчдыг төрийн одон медаль, салбарын шагналаар шагналаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 11	☁️ -13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	☁️ 29

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,528	3,532
EUR 🇪🇺	3,760	3,790
CNY 🇨🇳	512.50	514
RUB 🇷🇺	45.10	45.80
JPY 🇯🇵	26.60	26.80
KRW 🇰🇷	2.69	2.71

ЗУРХАЙ



ХАВРЫН ТЭРГҮҮН ХӨХ БАР САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ
УЛААГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Сүлд тэнэж одно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.56-19.03

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Өтлөх үхэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн.Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой.

КОРОНАВИРУС
ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 682,533,441

Эдгэрсэн

Нийт: 655,435,342

Нас барсан

Нийт: 6,819,806

Цахим шууданд

НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГЭЭС ЗЕНИТЧИН ДАЙЧДАД 16 ИЖ БҮРЭН МАЙХАН ГАРДУУЛЛАА



Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчний 102 жилийн ой босгон дээр Зэвсэгт хүчний 326 дугаар анги, нийслэлийн Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб хамтран “Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх өдөрлөг”-ийг зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр Сүхбаатар дүүргийн ЗДТГ-аас зенитчин дайчдад бэлэн байдлыг дээшлүүлэх, гэнэтийн гамшиг ослоос урьдчилан сэргийлэх хүрээнд 50 гаруй сая төгрөгийн үнэ бүхий 16 иж бүрэн майхан хүлээлгэж өгсөн юм.

Ёслолын ажиллагаанд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Ч.Цогтжаргал, нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг дарга Х.Болормаа, нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Г.Ялалт, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн дарга, хурандаа Д.Энхсайхан, Хуурай замын цэргийн командлалын Цэргийг агаарын довтолгооноос хамгаалахын дарга, хурандаа П.Мөнх-Эрдэнэ, Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Н.Гантөмөр

нарын албаныхан оролцсон юм.

Арга хэмжээг нээж бригадын генерал Ч.Цогтжаргал хэлсэн үгэндээ “Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, цэрэг эх оронч үзэл хүмүүжлийг түгээн дэлгэрүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлэхэд үргэлж тэргүүлэгч нь байсаар ирсэн Сүхбаатар дүүргийн ЗДТГ, Цэргийн штабын хамт олонд Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн бэлэн байдлыг дээшлүүлэхэд эд материалын дэмжлэг үзүүлж байгаад дайчин нөхдийнхөө өмнөөс талархал дэвшүүлбэ” хэмээсэн юм.

Үргэлжлүүлэн Сүхбаатар дүүргийн Засаг дарга Х.Болормаа хэлсэн үгэндээ “Сүхбаатар дүүргийн ЗДТГ, Цэргийн штаб хамтран батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, дайчилгааны бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Зэвсэгт хүчний 326 дугаар ангитай байнгын холбоотой, үйл ажиллагааг нь дэмжиж хамтран ажилладаг. 2020-2021 онд дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан халдвар хамгааллын хэрэгсэл, дархлаа дэмжих бүтээгдэхүүн, 2022 онд иж бүрэн компьютер, бусад

шаардлагатай дэмжлэгийг үзүүлж байсан бол өнөөдөр хээрийн гаралт, бэлтгэл сургалтад ашиглагдах иж бүрэн 16 майхныг гардуулж байгаадаа баяртай байна. Нөгөө талаас манай дүүргийн залуус энэхүү сайхан ангид алба хаадаг учраас бид хамтран ажиллахдаа таатай байдаг” гэлээ.

Үүний дараа Засаг дарга Х.Болормаа тэргүүтэй албаныхан тус ангид Сүхбаатар дүүргээс хугацаат цэргийн алба хааж байгаа дайчидтай уулзаж, санал сэтгэгдлийг нь сонсож, удахгүй болох “Монгол цэргийн өдөр”-ийн баярын мэнд хүргэлээ.

Хамтарсан өдөрлөгийн төгсгөлд тус дүүргийн ЗДТГ-ын дарга Н.Энхболдоор ахлуулсан дүүргийн хэлтэс, албадын дарга, мэргэжилтнүүд, хорооны Засаг дарга нар цэргийн сургалт бэлтгэлд хамрагдав. Сургалтаар Батлан хамгаалах бодлого, зорилт, орон нутгийн хамгаалалт, томилгоот нэгжийн бүтэц, гүйцэтгэх үүрэг, төрийн нууцын хадгалалт хамгаалалтын талаар мэдээлэл хүргэсэн бөгөөд энэ үеэр зенитчин дайчид албаныхаа онцлогийг харуулсан үзэсгэлэнг дэлгэсэн юм.

Х.ШАГДАРЫН ХӨДӨЛМӨР, БҮТЭЭЛИЙГ АЛДАРШУУЛАВ



БХЭШХ-ээс тус хүрээлэнгийн 45 жилийн ойг угтан цэргийн түүх, сургаж судлалын төвийн үйл ажиллагааг сурталчлах, эл төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, шинжлэх ухааны доктор

Ж.Өвгөнбүргэдийн уран бүтээлийн үзэсгэлэн дэлгэгдэж үзэгч олны хүртээл болсон юм.

Өдөрлөгийг нээж ҮБХИС-ийн эрдэм шинжилгээ хамтын ажиллагаа харууцсан дэд захирал



(Sc.D), профессор Х.Шагдарын хөдөлмөр бүтээлийг сурталчлах өдөрлөгийг зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Эрдэм шинжилгээ хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал доктор (Sc.D), профессор, хурандаа Б.Өлзийхуяг, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), дэд профессор хурандаа Д.Содномцог, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D) Ц.Цэрэндорж, “Монголын Артиллерийн цэргийн холбоо” ТББ-ыг төлөөлж бэлтгэл хурандаа Ж.Ванчинсүрэн, Монгол Улсын Ардын багш, доктор (Sc.D), профессор,

доктор (Sc.D), профессор, хурандаа Б.Өлзийхуяг үг хэлж доктор (Sc.D), профессор Х.Шагдарт баяр хүргэсний зэрэгцээ ҮБХИС-ийн удирдлагын гарын бэлгийг гардууллаа.

Үргэлжлүүлэн Цэргийн түүх, сургаж судлалын төвийн дарга, хошууч Т.Сүхбаатар тус төвийн өнгөрсөн жилүүдэд хийж гүйцэтгэсэн ажил болон доктор (Sc.D), профессор Х.Шагдарын намтар бүтээлийн талаар товч танилцуулга хийсэн юм.

Мөн энэ үеэр өөрийн амьдралын 30 гаруй жилийг цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд зориулж, дотоодод



бэлтгэл хурандаа Г.Мягмаржав, Соёмбо редакцын дарга, дэд хурандаа С.Ууганбаяр нарын хүндэт зочид болон Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн эрдэмтэн багш нар, сонсогчид, БХЭШХ-ийн эрдэмтэн судлаачид, ХХЕГ-ийн Хил судлалын хүрээлэнгийн төлөөлөл, доктор (Sc.D), профессор Х.Шагдарын шавь нар, гэр бүлийн төлөөлөл оролцлоо.

Өдөрлөгийн хүрээнд Цэргийн түүх, сургаж судлалын төвийн болон доктор (Sc.D), профессор Х.Шагдар болон түүний ууган шавь Хилийн цэргийн бэлтгэл хурандаа

танигдсан төдийгүй дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн профессор Х.Шагдарт Монгол улсын ардын багш, доктор (Sc.D), профессор Г.Мягмаржав, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат ажилтан, доктор (Sc.D), профессор О.Уржин, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат ажилтан, доктор (Sc.D), профессор Ш.Паламдорж, доктор (Ph.D), дэд профессор Ч.Сосорбарам, доктор (Ph.D) Ц.Цэрэндорж, бэлтгэл хурандаа Х.Чойжамц болон шавь нарын төлөөллөөс хүндэтгэл үзүүлээ.



ХАНДИВЫН АЯНД НЭГДЛЭЭ




Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн ахлагч П.Уламбаатарын охин Анударь нь төрөлхийн тархины саажилттай бөгөөд зүүн тархины 70% усжилттай. Уг өвчнийг Энэтхэг Улсын “New Delhi Aakash” эмнэлэгт 100% эмчлэх боломжтой юм.

Иймд Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн хамт олон мөрдэс нэгт нөхрийнхөө охиныг эдгэрч эрүүл болоход нь дэмжлэг үзүүлж сэтгэлийн хандив өргөлөө. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай

Уламбаатарын АНУДАРЬ ОХИНД АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЕ *Хандивын аян*

Хандивын данс:
Эзж Б.Чанцалсүрэн
5039314462

Миний охин Уламбаатар овогтой Анударь нь 2016 оны 4-р сарын 9-нд 7 сартай дутуу төрсөн төрөлхийн гидроцефалин гяргины усжилттай төрсөн. Төрсөнөөс хойш ЭХМҮТ-ийн хонилтад байж 2021 оны 3-р сард шунг тавих хагалгаанд орсон боловч амжилтгүй болсон. Охиноо эмчилж эдгээхийн тулд бид өнөөдрийг хүртэл бүхий л бололцоогоо дайчилж хөгжлөлтэй улс орны эмнэлгүүдэд хандсан юм.



Хүндэтгэсэн: Аав П.Уламбаатар, Эзж Б.Чанцалсүрэн, Охин У.Анударь
Холбоо барих: Аав - 8015-4417, Эзж - 8074-7161

Дарга дэд хурандаа
**САЙНБОЛДЫН
УУГАНБАЯР**

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний
Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
“Соёмбо” редакц
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс: 10018
Цахим шуудан:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)